- Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, Хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал" хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т Хүүхдийн цэцэрлэгийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон Хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн Хүүхдийн цэцэрлэг, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал "Хүүхдийн цэцэрлэгд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ"
 6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
 7. "Цэцэрлэг, Хүүхдийн цэцэрлэг/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам"-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
 8. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд

чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73,218.0 төгрөгөөр буюу 9.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	59,622.9	59,622.9
Авлага	-	1,454.9	1,454.9
Бараа материал	57,133.3	66,319.3	9,186.0
Үндсэн хөрөнгө	682,965.9	685,920.1	2,954.2
Нийт хөрөнгө	740,099.2	813,317.2	73,218.0
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	740,099.2	813,317.2	73,218.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	740,099.2	813,317.2	73,218.0

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 59,622.7 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 1,454.9 мянган төгрөгөөр өссөн нь аудитын явцад авлагаар залруулснаас нөлөөлсөн байна.
3. Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 9,186.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 11,000.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 69,046.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 70,865.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 2,954.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ, Орон нутгийн хөгжлийн сангаас хандиваар хөрөнгө хүлээн авснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 663,795.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 663,795.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 112,467.8 мянган төгрөгөөр бууруулж, 551,327.5 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 490,929.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 60,398.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 490,929.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 60,398.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 622.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 491,704.6 мянган төгрөг буюу 87.9 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг 59,622.9 мянган төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,900.0	1,900.0	-	100.0
2	81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	69,963.2	58,222.3	(11,740.9)	83.2
3	81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,094.0	2,094.0	-	100.0
4	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,900.0	1,900.0	-	100.0
5	81834 - Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	380,336.9	332,642.0	(47,694.9)	87.5
6	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	34,735.0	34,547.9	(187.1)	99.5
Дүн		490,929.1	431,306.2	(59,622.9)	87.9
Орон нутгийн төсвөөс					
1	80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41,748.0	41,748.0	-	-
2	80112 - Нийтлэг үйлчилгээ	18,650.4	18,650.4	-	-
Дүн		60,398.4	60,398.4	-	-
Нийт дүн		551,327.50	491,704.64	(59,622.9)	87.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3; 43.1.7 дугаар заалтын дагуу тэтгэвэрт гарахад нь олгох гэн удаагийн мөнгөн тэтгэмж 3 ажилтны 34,787.8 мянган, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 1 багшид 5,609.3 мянган, бичиг хэргийн зардал 103.5 мянган төгрөгийг олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.8-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгт төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 591,828.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,918.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,142.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 160 мэдээллийг бүрэн байршуулж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 391,833,980.00 төгрөгийн орлогын гүйлгээг 478,785,580.00 төгрөгөөр буюу 86,951,600.00 төгрөгөөр илүү, 1 удаагийн 6,826,000.00 төгрөгийн орлогын гүйлгээг 4,030,052.00 төгрөгөөр буюу

2,795,948.00 төгрөгөөр дутуу байршуулж, 4 удаагийн 97,891,300.00 төгрөгийн орлого, 3 удаагийн 83,228,500.00 төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, заавар аргачлалаар хангаж ажиллуулах зөвлөмж өгөв.

Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд хэрэгцээ шаардлагаас илүү 4,470.3 мянган төгрөгийн хүнсний материалыг нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;” санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг 3,892.4 мянган төгрөгөөр хэтрүүлсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, 462,608.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	8,075.4	2	8,075.4	100.0
Албан шаардлага	1	3,568.2	1	3,568.2	100.0
Зөвлөмж	1	462,608.5	2	270,867.3	59.0
Нийт дүн	4	474,252.1	5	282,510.9	60.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 748,211.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 741,554.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.Үүнд:

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүйг;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалин хөлсний дүн, ерөнхий журналын цалин хөлсний зардлын дүнгээс 1,454.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэнийг авлагаар бүртгүүлж;
- Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 740,099.2 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.
- Үр дүнгийн тайлан дах хоолны зардал нярвын тайлангаас 6,657.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэнийг; тус тус залруулсан.

Аудитаар нийт 14,469.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,086.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 12,383.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт тогтоох

5.1.1 Ирцийн бүртгэлгүйгээр зуны цэцэрлэгийн хоолны зардлаар 2,086.4 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.2 Албан шаардлага

Батлагдсан орон тоог 1 орон тоогоор илүү ажиллуулж/ арга зүйч/ 4,020,520.00 төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.2-т "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;" санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.5-т "Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн;" дагуу Албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх зөвлөмж өгөв.

5.3.2. Хүний нөөцийн талаар

Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн нягтлан бодогч нь Сумын ЗДТГ-ын нягтлан бодогчийг орон тоогоор, ИХ, цэцэрлэгийн нягтлан бодогчийг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" 19.1-д "Бүх шатны төсөв нь тухайн шатны төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тоог баримталж нягтлан бодогчийг орон тоогоор ажиллуулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.	1	-			1	-	1	-				
Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 1,454.9 мянган төгрөгийг зөрүүтэй байна.	1	1,454.9			1	1,454.9	1	1,454.9				
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 740,099.2 мянган төгрөгийг залруулаагүй байна.	1	740,099.2			1	740,099.2	1	740,099.2				
Үр дүнгийн тайлан дах хоолны зардал нярвын тайлангаас 6,657.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна	1	6,657.2			1	6,657.2	1	6,657.2				
Дүн	4	748,211.3			4	748,211.3	4	748,211.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ирцийн бүртгэлгүйгээр зуны цэцэрлэгийн хоолны материалаар 2,086.4 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан.	1	2,086.4	1	2,086.4								
Батлагдсан орон тоог 1 орон тоогоор илүү ажиллуулж/ арга зүйч/ 4,020.5 мянган төгрөгийн цалин олгосон байна.	1	4,020.5			1	4,020.5						
Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-					1	-				
Тус цэцэрлэгийн нягтлан бодогч нь Сумын ЗДТГ-ын нягтлан бодогчийг орон тоогоор, ИХ, цэцэрлэгийн нягтлан бодогчийг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.	1	-					1	-				
Дүн	4	6,106.9	1	2,086.4	1	4,020.5	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 160 мэдээллийг бүрэн байршуулж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 391,834.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 478,785,580.00 төгрөгөөр буюу 86,951.6 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 6,826.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 4,030.1 мянган төгрөгөөр буюу 2,795.9 мянган төгрөгөөр дутуу байршуулж, 4 удаагийн 97,891.3 мянган төгрөгийн орлого, 3 удаагийн 83,228.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.	1	270,867.4			1	270,867.4		
Дүн	1	270,867.4			1	270,867.4		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сувиллын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-					1	-
Гүйцэтгэлд суурилсан төсвийг цөөн нэр төрлөөр баталснаас шалтгаалж, тээвэр шатахуун, томилолт, сургалт, хөрөнгө бэлтгэх зэрэг зардлуудыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын ангилал, дансаар ангилж бүртгээгүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тайлагнаагүй байна.	1	-			1	-		
Хүүхдийн хоол хүнсний материалд 4,470.3 мянган төгрөгийг нөөцөлсөн байна.	1	4,470.3			1	4,470.3		
Түлш халаалтын зардал төлөвлөгөөнөөс 3,892.4 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.	1	3,892.4			1	3,892.4		
Дүн	4	8,362.7			3	8,362.7	1	-
Нийт дүн	4	279,230.1			4	279,230.1	1	-